

Группийн бодлого

Хүндэтгэл, хүртээмж, олон талт байдлын бодлого

HR-A-003

Ангилал: Стандарт, Бодлого	Үйл ажиллагаа: Хүний нөөц	Хуудасны тоо: 3
Баталсан: 2025 оны 1-р сарын 7	Хүчин төгөлдөр болох: 2025 оны 1-р сарын 7	Аудит хийх хугацаа: 2025 оны 1-р сарын 7
Хүчингүй болгох: HR-A-002 Хүртээмж, олон талт байдлыг дэмжих бодлого		
Хариуцагч: Авьяас, ур чадварын газрын захирал	Баталсан: Хүний нөөц хариуцсан захирал	Зорилтот бүлэг: Бүх ажилтан, гол гэрээт ажилтан. Гол гэрээт ажилтнууд гэж 1 болон 2-р ангиллын гэрээт ажилчид, мөн Рио Тинтогийн дотоод системд хандах эрхтэйгээр дотоод ажил үүрэг эрхэлж байгаа эсвэл Рио Тинтог төлөөлөн бусад үйл ажиллагаа явуулдаг бүх гэрээт ажилчид, төлөөлөгчид, зөвлөхүүд, бусад үйлчилгээ үзүүлэгчдийг хэлнэ.

Бусад холбогдох бодлого, стандарт, журам эсвэл удирдамжийг шууд үзэх холбоос:

- Бидний ажлын арга барил (Ес зүйн дүрэм) - [Our Code of Conduct - The Way We Work](#)
- Группийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого - [HR-A-001 Employment Policy](#)
- Хүний эрхийг хамгаалах бодлого - [CSP-A-001 Human Rights Policy](#)
- Бизнесийн ёс зүйн стандарт - [GOV-B-001 Business Integrity Standard](#)
- Бизнесийн ёс зүйн журам - [GOV-C-002 Business Integrity Procedure](#)
- myVoice стандарт - [GOV-B-004 myVoice стандарт](#)

Баримт бичгийн зорилго:

- Компани дотроо болон Рио Тинтогийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлд хүчирхийлэл, дарамтаас ангид, аюулгүй, хүртээмжтэй, хүндэтгэлтэй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн Рио Тинтогийн амлалтыг хэрэгжүүлэх зарчмыг тодорхойлоход оршино.

Хүндэтгэл, хүртээмж, олон талт байдал нь Рио Тинтогийн үнэт зүйлс төдийгүй бүтээлч байдал, инновац, өсөлтийг дэмжих үндсэн суурь болдог. Бид бүх түвшинд аюулгүй, хүртээмжтэй, хүндэтгэлтэй ажлын харилцааг бүрдүүлэхийн төлөө тууштай ажилладаг, ингэснээр бүх ажилтнуудад маань арьс өнгө, үндэс угсаа, хүйсийн илэрхийлэл, бэлгийн чиг баримжаа, нас, хөгжлийн бэрхшээл, шашин шүтлэг, сэтгэхүйн ялгаатай байдал зэргээс үл хамааран тав тухтай байж, үнэ цэнтэйгээ мэдэрдэг. Ажилтнууд маань ажил дээрээ аюулгүй байдал, хүндлэл, хүртээмжийг мэдэрсэн цагт хөгжиж дэвшиж, ажлын гүйцэтгэл нь сайжирч байдаг. Энэ итгэл үнэмшил бидний үйлдэл, шийдвэрийг удирдан чиглүүлж, илүү хүндэтгэлтэй, эрх тэгш ажлын орчныг бүрдүүлэх болно.

Бид бүх гишүүд нь харьяалагдаж байгаагаа мэдэрдэг, янз бүрийн үзэл бодлыг үнэлдэг, ялгаварлалгүй орчин бүрдүүлэхийг зорьдог. Бид хүндэтгэл, хүртээмж, олон талт байдлыг эрхэмлэн хэрэгжүүлдгээ бодлого, үйл ажиллагаа, соёлоороо харуулдаг. Бид олон янзын авьяас, ур чадварыг идэвхтэйгээр татаж, хөгжүүлж, тогтвортой ажиллуулж, бүх хүн дуу хоолойгоо илэрхийлэх нээлттэй хүртээмжтэй орчныг бүрдүүлдэг.

Бид хүндэтгэл, хүртээмж, олон талт байдлыг соёл, үйл ажиллагааныхаа үндэс суурь болгож, тасралтгүй суралцах, сайжруулахын төлөө тууштай ажилласаар байна.

Энэхүү бодлого нь Рио Тинтогийн ажилтнууд, гэрээт ажилчид, түншүүд, нийлүүлэгчид зэрэг Рио Тинтогийн удирдлага дор ажиллаж буй бүх хүмүүст хамааралтай. Рио Тинтогийн ажилтнууд Рио Тинтог илүү аюулгүй, хүртээмжтэй, хүндэтгэлтэй байгууллага болгоход ямар үүрэгтэйгээ мэддэг байх ёстой.

Рио Тинтогийн ажилтнууд дараах үүрэгтэй:

- Бусдын нэр төрийг эрхэмлэн, хүндэтгэлтэй харьцах
- Энэ Бодлого, мөн "Бидний ажлын арга барил"-ыг дагаж мөрдөх
- Таны зан харилцаа, үйлдэл бусдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх ёстой
- Эрх тэгш байдал, олон талт байдал, хүртээмжтэй, хүндэтгэлтэй зан харилцааны сургалт болон бусад хамрагдах ёстой бүх сургалтад хамрагдах, дүүргэх
- Хэрэв та хортой зан харилцааг харсан бол зөвийг дэмжигч байж, үйлдэл хийж, хортой харилцаанд өртсөн хүмүүст дэмжлэг үзүүлээрэй. Тухайн нөхцөл байдлаас хамаараад хөндлөнгөөс оролцож болох ба дараах алхмуудыг хэрэгжүүлж болно:
 - Шууд: тухайн үед нь шууд хэлэх.
 - Шууд бус: Тухай явдлын дараа хүндэтгэлгүй хандсан/ хохирол учруулсан хүнтэй холбогдох.
 - Сарниулах: Тухайн үед нь шууд сөргөлдөхөөс зайлсхийж, анхаарлыг өөр зүйлд хандуулах замаар нөхцөл байдлыг зөөлрүүлэх.
 - Протокол: Энэхүү баримт бичгийн дараагийн хэсэгт дурдсан байгууллага доторх дэмжлэг үзүүлэх мэргэжилтнээс тусламж дэмжлэг хүсэх, үүнд мэдээлэх хувилбар орж болно.

Удирдах ажилтнууд дараах нэмэлт үүрэг хариуцлага хүлээнэ:

- Ажилд авах үйл явцад ажил горилогчдод, хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд багийнхаа гишүүдэд ижил тэгш, хүртээмжтэй, хүндэтгэлтэй хандаж, бүх хүнд шударга, тав тухтай орчныг бүрдүүлэх.
 - Гэрээт ажилчдыг оролцуулан бүх хүнд энэхүү Бодлого болон түүний хүрээнд хүлээх үүрэг хариуцлагыг ойлгоход туслах.
 - Ажлын байрны журмууд болон хүний нөөцийн үйл ажиллагааг хүртээмжтэй, аливаа өрөөсгөл хандлага, ялгаварлан гадуурхалтаас ангид байдлаар хэрэгжүүлэх.
 - Ялгаварлан гадуурхалт, хортой эсвэл зохисгүй зан харилцааны талаар мэдээлэхийг дэмжих.
 - Баг дотроо сэтгэлзүйн аюулгүй байдлыг бий болгож, аюулгүй, хүндэтгэлтэй, хүртээмжтэй ажлын орчныг дэмжиж, хортой зан харилцааны талаар нээлттэй, илэн далангүй ярилцах нөхцөлийг бүрдүүлэх.
 - Хортой зан харилцааг гаргаж байж магадгүй гэж сэжиглэж байвал шуурхай арга хэмжээ авч, дэмжлэг үзүүлэх.
 - Хортой зан харилцааны эрсдэлийг удирдаж, бууруулах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх.
-

Рио Тинтод бид хортой зан харилцааг хүлээн зөвшөөрөхгүй. Эдгээр зан харилцаа нь хүний аюулгүй байдал, сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлдөг. Үүнд дараах зүйлс орно:

Дээрэлхэл: Бусдыг үндэслэлгүйгээр айлган сүрдүүлэх, доромжлох, гутаах.	Ажлын байртай холбоотой хүчирхийлэл: Ажлын байранд гарсан бие махбодын халдлага, хүчирхийлэл болон заналхийлэл.
Дарамт: Бусдыг дорд үзсэн, доромжилсон, заналхийлсэн давтагдах чанартай зан үйлдэл. Бие махбодын, үгэн болон үгэн бус үйлдлүүд багтана.	Арьс өнгөөр ялгаварлах: Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, тэгш эрхтэйгээр эдлэх, хэрэгжүүлэхийг үгүйсгэх, саад учруулах зорилго, үр дагавар бүхий арьс өнгө, арьсны өнгө, удам угсаа, улс үндэс, яс үндсээр ялгаварлах, гадуурхах, хязгаарлах, шилж сонгох үйлдэл.
Бэлгийн дарамт: Доромжилсон, айлган сүрдүүлсэн, гутаасан бэлгийн шинжтэй хүсээгүй үйлдэл.	
Ялгаварлан гадуурхалт: Хүний хувийн шинж чанаруудад суурилсан таагүй хандлага.	Хариу арга хэмжээ авах, шахаж хавчих: Хортой зан харилцааг мэдээлснийх нь төлөө эсвэл шалгах ажиллагаанд оролцсоных нь төлөө шийтгэх.
Гутаан доромжлол: Олон нийтийн дунд үзэн ядалт, жигшил зэвүүцэл, доог тохууг өдөөсөн үйлдлүүд	

Рио Тинто нь дараах хувийн шинж чанарт үндэслэн ялгаварлан гадуурхахыг хүлээн зөвшөөрөхгүй:

Нас	Эцэг эхийн статус эсвэл гэр бүл, асран хамгаалагч, хамаатан садны үүрэг хариуцлага
Арьс өнгө, гарал үүсэл	Улс төрийн итгэл үнэмшил, үйл ажиллагаа
Хүйсийн илэрхийлэл	Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа (үүнд үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын холбооны гишүүн байх г.м)
Хүйс эсвэл хүйсийн онцлог (жишээ нь, бэлэг эрхтэн)	Гэр бүлийн болон ахуйн хүрээний хүчирхийлэлд өртөж байсан эсэх
Иргэншил (удам угсаа, угсаа гарвал, эсвэл яс үндэс, нийгмийн гарал, эсвэл улс үндэсний гарал үүсэл зэрэг)	Дээрх шинж чанаруудын аль нэгийг нь агуулсан эсвэл байгаа гэж тооцогддог хүнтэй холбоо хамааралтай байх
Шашны итгэл үнэмшил, үйл ажиллагаа	Бэлгийн чиг баримжаа
Бие махбодын болон сэтгэл зүйн бэрхшээл, эрүүл мэндийн байдал (ХДХВ/ДОХ-ын статус орно)	Гэрлэлт болон гэр бүлийн байдал
Жирэмслэлт, жирэмслэх магадлал, мөн хүүхдээ хөхүүлэх, сүүгээ саахтай холбоотой нөхцөл байдал	Таны ажиллаж буй улсад хамгаалагдсан бусад шинж чанарууд

Хэрэв та ямар нэгэн хэлбэрийн хортой зан харилцаанд өртсөн эсвэл харсан бол энэхүү асуудлыг аль болох эрт шийдвэрлэхийг зөвлөж байна. Та дараах хүмүүсээс дэмжлэг авч болно:

- Удирдах ажилтан, хамтран ажиллагч, Хүний нөөцийн багийн ажилтан,
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны багийн ажилтан,
- Ажилтны дэмжлэгийн сүлжээ,
- Дэмжин туслах төв
- Ёс зүй, Хууль, дүрэм, журмын хэрэгжилт, эсвэл Хуулийн баг.

Хэрэв та Рио Тинтотой холбоотой зохисгүй үйлдэл, хортой зан харилцаатай холбоотой асуудалд санаа зовниж байгаа бол [myVoice](#) платформоор дамжуулан энэ талаар нууцлалтайгаар мэдээлж болно. Мөн таны удирдах ажилтан, хамтран ажиллагч, Хүний нөөц эсвэл Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагааны багийн гишүүн, эсвэл [Дэмжин туслах төв](#) таны өмнөөс мэдээлэхэд туслах боломжтой. Манай удирдах ажилтнууд сэтгэлзүйн аюулгүй байдлыг бүрдүүлэхийн төлөө тууштай ажилладаг тул та аливаа санаа зовоосон асуудлаа хариу арга хэмжээ авах вий гэсэн айдасгүйгээр илэрхийлэх боломжтой. Дэмжин туслах төв нь хүн төвтэй, гэмтлийн мэдээлэлд суурилсан дэмжин туслах үйлчилгээг санал болгож, шийдэх, эдгэрэх боломж хувилбаруудыг олоход тань тусална.

Мэдээлсэн бүх тохиолдлыг нухацтай авч үзэн, шуурхай бөгөөд шударга байдлаар хянан үзнэ. Нөлөөлөлд өртсөн хэн бүхэн [Ажилтанд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт](#) (АДҮХ) -д хандан мэргэжлийн зөвлөгөө авах боломжтой.

Бид хувь хүмүүсийг хортой зан харилцаатай холбоотой үзсэн туулснаа хуваалцахыг нь Мэдээлэл нууцлах гэрээ байгуулах зэргээр хориг тавьдаггүй. Бид ил тод байж, хувь хүмүүс хариу арга хэмжээ авах вий гэсэн айдасгүйгээр өөрсдийн туршлагаа ярих эрхтэй гэдэгт итгэдэг.

Бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, тэр дундаа 2019 оны Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын "Хүчирхийлэл, дарамтыг халах тухай" конвенц (№190)-ийг хэрэгжүүлдэг бөгөөд ажлын байран дахь бүх төрлийн хүчирхийлэл, дарамт, түүний дотор хүйсийн ялгаатай холбоотой хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохыг тууштай эрмэлздэг.

Манай албан газарт, цахимаар, ажлаас гадуурх байршлуудад, гэрээсээ ажилладаг, мөн гуравдагч талуудтай харилцах, ажилтай холбоотой арга хэмжээнд оролцох зэргээр Рио Тинтотой хамтарч ажилладаг бүх хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хамгаалахын төлөө бид тууштай ажиллана. Хортой зан харилцааны эсрэг зогсож, алхам хийсний хариуд арга хэмжээ авч, шахаж хавчих вий гэх айдас төрүүлдэггүй, хүндэтгэлтэй, сэтгэлзүйн аюулгүй байдлыг хангасан соёлыг төлөвшүүлэх болно.

Бид дэлхий дахинд үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн хэрээр хүндэтгэлтэй, хүртээмжтэй, олон талт байдлыг дэмжсэн ажлын орчныг бүрдүүлэхийг тууштай зорих болно. Энэхүү бодлого нь группийн ажилчдын дагаж мөрдөх стандарт төдийгүй цаашид ажлын байрны соёлыг бэхжүүлэх төсөл санаачилга хэрэгжүүлэх хөрс нь болно.
